

## ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ИРКУТСК ХОТ ДАХЬ “АЭРОНАВИГАЦИЯ ВОСТОЧНОЙ СИБИРИ” БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАСАН АЖЛЫН ТАЙЛАН

Оросын холбооны улсын Иркутск хот дахь “Аэронавигация восточной сибери” байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 30-наас 06 дугаар сарын 04-ны өдрүүдэд уулзалтыг зохион байгуулсан.

Тус уулзалтанд Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/291 дугаар тушаалаар томилогдсон Иргэний нисэхийн ерөнхий газрыг төлөөлөн Иргэний нисэхийн үндэсний төвийн үйлдвэрлэл үйлчилгээний газрын дарга Г.Мөнгөнхуяг, Нисэхийн холбоо, навигац, ажиглалтын албаны дарга Г.Баттөгс нар оролцсон.

### УУЛЗАЛТААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛУУД

Улаанбаатар-Иркутск бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүд хоорондын нислэгийн хөдөлгөөний удирдлагын харилцан зохицуулалтын гэрээний нэмэлт өөрчлөлтүүдийн талаар ОХУ-ын “Аэронавигация Восточной Сибири” байгууллагын удирдах албан тушаалтнуудтай уулзалт хийж, туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хэлэлцсэн.

1 Монгол улсын агаарын навигацийн үйлчилгээний хөгжлийн чиг хандлага, түүний хүрээнд авч хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа төсөл хөтөлбөр, “Хил хязгааргүй нисэх - 2030” стратеги төлөвлөлтийн хүрээнд дэлхий нийтийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн техник технологи, түүний хэтийн хэрэгжилтийн талаар танилцуулсан.

2 Оросын Холбооны Улсын “Аэронавигация Восточной Сибири” байгууллагын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1001.1.6-57 дугаартай албан бичгийн дагуу хиймэл дагуулын холбооны газрын станцын үйлчилгээг “Экспресс-АМ5”-аас “Экспресс-АМУ7” хиймэл дагуулд шилжүүлэх туршилт шалгалтын ажлын үр дүнг хэлэлцэв. Үүнд:

2.1. Оросын Холбооны Улсын “Аэронавигация Восточной Сибири” байгууллагын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1001.1.6-57 дугаартай албан бичгийн дагуу Иркутск хотын бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвтэй холбогдон ажилладаг хиймэл дагуулын холбооны газрын станцын үйлчилгээг “Экспресс-АМ5”-аас “Экспресс-АМУ7” хиймэл дагуулд шилжүүлэх туршилт шалгалтын ажлыг 2024 оны 03 дугаар сарын 28-наас 04 дүгээр сарын 04-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцсэн.

2.2. Оросын Холбооны Улсын “Хиймэл дагуулын холбооны компани”-аас 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 16-04-03/1910 дугаартай албан бичгийн талаар буюу Улаанбаатар хотын бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн хиймэл дагуулын холбооны газрын станцад ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүд нь параметрийн зөрүүтэй, шаардлагад нийцэхгүй байгаа талаар харилцан санал солилцов.

2.3. Цаашид хиймэл дагуулын холбооны газрын станцын тоног төхөөрөмжүүдийн параметрийн зөрүүтэй байдлыг арилгах, шаардлагад нийцүүлэхийн тул техникийн шийдлийг нэн даруй гаргах нь зүйтэй гэж талууд хүлээн зөвшөөрөв.

3 Оросын Холбооны Улсын “Хиймэл дагуулын холбооны компани”-аас 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 16-04-03/1910 дугаартай албан бичгээр ирүүлсэн Улаанбаатар хотын нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвд ашиглагдаж байгаа хиймэл дагуулын холбооны газрын станцад ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүд нь параметрийн зөрүүтэй, шаардлагад нийцэхгүй тухай мэдэгдлийн талаар харилцан

санал солилцож ИНЕГ-аас танилцуулсан техникийн шийдлийг талууд харилцан зөвшөөрч дараах тоног төхөөрөмжүүдийг суурилуулан ашиглахаар шийдвэрлэв. Үүнд:

- 3.1. CDM-570AL-IP satellite modem. /CDM-570AL-IP L-Band Satellite IP Modem Standard CEFD Front Panel 100 - 240 VAC Primary Power (No BUC Power Supply), 2.4 kbps - 10.239 Mbps Data Rate, Standard and 8PSK and 8QAM and 16QAM 5% 10% 15% 20% 25% for Transmit up to 10.239 Mbps (CCM Mode) / 3000 ksps (ACM Mode) 2nd Generation Turbo Codec Rate: 5/16 21/44 3/4 and 7/8 Vipersat Enabled IP Packet Processor Quality of Service CDM-570AL-IP Accessories European/French - AC Cord CLI Remote Cable Standard 2 Year Hardware Warranty Included
- 3.2. NJRC LNB /NJS8486UN C-band LNB/
- 3.3. NJRC BUC /NJT5669N C-band 5W BUC/

4 ОХУ-ын "Хиймэл дагуулын холбооны компани"-тай 2007 онд байгуулсан Улаанбаатар-Иркутск бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүд хоорондын нислэгийн хөдөлгөөний удирдлагын харилцан зохицуулалтын 100-16-03-15/31/2007 дугаар гэрээнд 7 дугаар гэрээний нэмэлт өөрчлөлтүүдийн талаар: Үүнд:

- 4.1 Хиймэл дагуулын холбооны газрын станцын үйлчилгээг "Экспресс-AM5"-аас "Экспресс-AMУ7" хиймэл дагуулд шилжүүлэн цаашид "Экспресс-AMУ7" хиймэл дагуулыг ашиглах талаар нэмэлт гэрээнд тусгах.
- 4.2 RSCC нь Express-AMУ7 (145E) хиймэл дагуулын транспондоруудаар дамжуулан холбооны суваг (цаашид холбооны суваг гэх) бий болгох зорилгоор сансрын сегментэд нэвтрэх (цаашид "үйлчилгээ" гэх) үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлнэ. Үүнд:
  - 2024.04.01-ний өдрөөс эхлэн транспондер 11, зурвасын өргөн 60кГц болгох.
- 4.3 2007 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 100-16-03-15/31/2007 дугаартай хэлэлцээрийн дагуу 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үйлчилгээ үзүүлсний төлбөр сард 18176.88 рубль буюу 88/100 тооцох.

## ТУРШЛАГА СОЛИЛЦОХ ЧИГЛЭЛЭЭР

Иргэний нисэхийн ерөнхий газрын төлөөлөгчид нь ОХУ болон Монгол Улсын хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх зорилгоор Оросын холбооны улсын Иркутск хот дахь "Аэронавигация восточной сибери" байгууллагын үйл ажиллагаатай танилцсан.

## ДҮГНЭЛТ


Тус уулзалтанд оролцсоноор Улаанбаатар-Иркутск бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүд хоорондын нислэгийн хөдөлгөөний удирдлагын харилцан зохицуулалтын гэрээний нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулж, ОХУ болон Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэж буй олон улсын нислэгүүдэд агаарын навигацийн үйлчилгээг аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй үзүүлэхэд шаардлагатай техник, технологийн шийдлүүдийг харилцан тохиролцож, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт шаардлагад нийцсэн нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээг үзүүлэх, хоёр улсын агаарын зайн ашиглалтыг сайжруулах, хоёр улсын агаарын навигацийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг улам бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой уулзалт болсон гэж дүгнэж байна.

ТАНИЛЦСАН:  
АГААРЫН ТЭЭВРИЙН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА



Г.БАТБАЯР

ХЯНАСАН:  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ

БОЛОВСРУУЛСАН:  
НИСЭХИЙН ХОЛБОО, НАВИГАЦИ,  
АЖИГЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА



Г.БАТТӨГС